



“ХӨХ СУДАР” СУДЛАЛ ДАХЬ ИНЖИНАШИЙН УТГА ЗОХИОЛЫН ҮЗЭЛТИЙН СУДАЛГААНЫ ТУХАЙ ЗАРИМ АСУУДАЛ

Заяатай, доктор

ӨМИС, Олон улсын Сурган Хүмүүжлийн Дээд сургууль

Резюме: Изучение “Хөх судар” и некоторые проблемы литературоведческих взглядов Инжинаши. В данной статье рассказывается об исследовании Намжилцэвэг, ученого из Внутренней монголии. Намжилцэвэг защитил кандидатскую диссертацию в 1959 году по этой теме в Монголии. Большую часть исследования посвящается изучению “Товчит толь”- кратко изложению “Хөх судар”. Автор статьи излагает свою концепцию по слепующим аспектам:

- Философские взгляды “Товчит толь”
- Социальные идеи “Товчит толь”
- Эстетические взгляды Инжинаши, выраженные в “Товчит толь”.

Автор дальше говорит о влиянии издания “Хөх судар” в 1940 году во Внутренней Монголии. А также приведены цитаты из исследования академика Ц.Дамдинсүрэн, немецкого учёного В.Хайссиг и Ш.Чоймаа.

Түлхүүр үг: Инжинаш, Хөх судар, товчит толь, Намжилцэвэг,

Удиртгал

Эрдэмтэн Намжилцэвэг 1959 онд “Хөх судар” судлалаар Монгол улсад дэд эрдэмтэний зэрэг хамгаалсан бөгөөд тэрээр Инжинашийн “Хөх судар”-ыг талаас нь түүхэн роман болох хамгийн анх системтэй шинжлэн судалсан учир Монгол туургатны утга зохиолын түүхэнд чухал байр суурийг эзэлдэг болно.

“Хөх судар” судлалын бүтээл нь оршил, удиртгал, дөрвөн бүлэг, хавсралт, ном зүй, номын бүртгэлээс бүрдэх бөгөөд өрнийн болон Монгол эрдэмтдэд зориулсан “Хөх судрын товчлол” зэрэг хураангуй өгүүлэл зэргээс бүрэлдсэн байдаг.

1. “Хөх судар”-ын товчит тольтийн судлал

Намжилцэвэг “Хөх судар”-ын товчит тольтийг “Хөх судар”-ын судлал бүтээлдээ тусгай нэг бүлэг болгон судалсан юм. Өгүүлэлд Инжинашийн “Хөх судар”-ын товчит тольтийн гүн ухааны үзэл санаа, нийгмийн байдал болон уран зохиолын талаарх судалгааг онолын өндөр түвшинд маш гүнзгий, нарийн системтэй задлан шинжилсэн байдаг. Энэ нь Инжинашийн үзэл санааны тухай шинжлэх ухааны судалгаа болсон тул Намжилцэвэгийн бүтээлч оролдлого, дүгнэлтийг сайшаан үзэж болохоор байна.

Нэг. “Хөх судар”-ын товчит тольтийн гүн ухааны үзэл санаа:

“Хөх судар” -ын товчит тольтийн гүн ухааны үзэл санааны талаар Намжилцэвэг товчит тольт дотроос түүний сонгодог үзэл санааг илтгэж содон гайхам үгнүүдийг сонгон авч Инжинашийн гүн ухааны үзэл санааг доорх мэт хэдэн талаас шинжлэн судалсан байна.

1. Бодис бол анхдагч, оюун бол хоёрдогч гэх санаа;
2. Байгал нийгэм болбоос өөрийн тогтсон хууль жамтай бөгөөд түүний хууль жамыг хүмүүн танин мэдэж чадмой хэмээх санаа;
3. Алив зүйл цөм мөнх бус үргэлж хувьсан өөрчлөгддөг хэмээх санаа;
4. Алив зүйл цөм хоорондоо харилцаа холбоотой гэх санаа;

Тийнхүү Намжилцэвэг Инжинашийн гүн ухааны үзэл дээр тулгуурлан дүгнэхдээ түүнийг материаллаг үзлийг баримталж байсан төдийгүй диалектикийн хуулийг

баримталж байсан тухай дурдсан юм.

Хоёр. “Хөх судар”-ын товчит тольтийн нийгмийн үзэл санаа

“Хөх судар”-ын товчит тольтийн нийгмийн үзэл санааны талаар:

1. Инжинаш шашны үзэл санааг эсэргүүцэгч байсан;
2. Инжинаш бол эгэл иргэдийг өрөвдөх, баяд ноёдын муу зан суртал болон үзэл сэтгэлгээг жигшин шүүмжлэгч байсан;
3. “Эрдэмтэн Инжинаш зөвхөн Монгол түмэндээ хайртай төдийгүй эл үндэстний ард түмнийг цөм эрх тэгш байлгахыг эрмэлзэж байсан хүн болмой” гэж үзээд түүний тэгш эрхийг эрхэмлэгч байсныг дурдсан байсан.
4. Инжинаш “Хөх судар” түүхэн романдаа шашныг хатуугаар шүүмжилсэн боловч.... шашныг бүрмөсөн устгахыг зорьсонгүй” хэмээжээ. Иймээс Инжинаш бол **гэгээрүүлэгч** үзэлтэн мөн хэмээн үзэж болохоор байна.

Гурав. “Хөх судар”-ын товчит дундад харагдах Инжинашийн урлагийн талаар баримталж байсан онол, үзэл баримтлал

Намжилцэвэг “Инжинаш зөвхөн уран зохиолч төдий биш, уран зохиолын онол, гүн ухааныг нэлээд гүнзгий судалж байсан агаад тэрээр тухайн үеийн монголын гарамгай эрдэмтний нэг байжээ” хэмээн дүгнэсэн байдаг. Инжинашийн Монголын утга зохиол болон Монголын үзэл санааны үйлст үзүүлсэн зүтгэлийг дурдахын сацуу “Хөх судар”-ын товчит дундуудад “Инжинашийн уран зохиолын талаар баримталж байсан үзэл онолын гоё санаа илэрч байна” гээд Инжинашийн Монгол туургатны утга зохиолын онолд түүний оруулсан хувь нэмрийг тодруулан дурджээ.

1. Инжинаш уран зохиолыг юу гэж үзэж байсан тухай:

Намжилцэвэгийн үзэхээр Инжинаш бол “Улс улсад зохиогдох бөгөөд улс улсын зан суртлын аяыг дагаж бичигдсэн зүйл нь хоорондоо харилцан адилгүй”, “Улс улсын онцлог уран зохиолд тусдаг учраас харилцан өөр

болдог хэмээсэн нь адил бус нийгмийн амьдралаас адил бус чанартай уран зохиол төрж гардаг тухай өгүүлжээ.

Иймээс уран зохиол гэдэг бол нийгмийн амьдралын уран тусгал мөн гэж Инжинаш үзэж байжээ” хэмээн дүгнэн бичсэн байна.

2. Уран зохиолын өвөрмөц чанарын талаар дурдсан үзэл;

Энэ хэсэгт Инжинашаас “... Уран зохиол нь түүхийн зохиолоос эрс ялгавартай...” гэдэг үзэл нь тодорхой харагддаг гэж бичсэн байна. Намжилцэвэг бээр Инжинашийн уран зохиолын өвөрмөц чанарыг хоёр талаар нарийвчлан тодорхойлж билээ.

Нэгд: Инжинашийн хэлсэн “...үзгэн төдий ор сэдэв байваас, мэргэд бээр даруй түүнд зуун үйлийн учир шалтгаан нэмж, санаа сүйхээ ургуулан түмэн мянган давхар чимэх уянга нэмж...” урлан бүтээх уран зохиолын өвөрмөц жам хуулийг тодорхойлжээ.

Хоёрт: Намжилцэвэг багш Инжинашийн уран зохиолын өвөрмөц чанарыг үзэхдээ “үндэстэн бүрт уран зохиол өвөрмөц онцлогтой байдаг гэснийг тодруулан шинжилжээ. “... үзтэл хятад үгс сүүл даран хэлж, Монгол үг толгой холбон өгүүлэх ба Төвөд түргэн дөтийг эхэлж, Манж үсэг тус тааруулан зохиожээ” гэдгийг жишээлж байгаад үндэстнүүдийн уран зохиол цөм “Өөр өөрийн өвөрмөц хэлбэр онцлогтой” байдаг болон үндэсний уран зохиолын хэлбэрийн өвөрмөц чанарын гоо сайхныг тодруулан өгүүлжээ. Яриангүй, хэлбэрийн сайхан бол, нүдний чимэг юм. Намжилцэвэг эдгээр тайлалаа үргэлжлүүлээд “Уран зохиол гэдэгт урлаг дутаж болохгүй. Аль нэг нь дутвал уран зохиол биш зөвхөн уран үгс буюу улс төрийн зохиол хоёрын нэг болно” хэмээжээ. Уран зохиолд урлаг бол түрүүн, бас ч агуулгагүй урлагийн бүтээл гэж байдаггүй, урлаг агуулга хоёр бол уран бүтээлд органикаар зохицож чадмагц сая аль болохуйц төгөлдөр сайхан уран бүтээл зохиогддог юм.

3. Уран зохиолд бичигдэх зүйл ба бичих аргын талаар баримталж байсан зүйлийн тухайд Намжилцэвэг “Хөх судар”-ын товчит дундад өгүүлсэн Инжинашийн “Өөрийн үл итгэмжлэх сэтгэлийг зөрчүүлэн мөшгиж мөн олон судрын ёсоор түүний доторх



сонин сэвүүн увидас илбэс хийгээд этгээд онцгой ер бэлгэс ба нэн бас дээр сахиулсны ивээл харгалзаа хувилгаан чөтгөрийн дагаж тусалсан зэрэг учир явдал...”-ыг бичсэн зүйлсийг жишээлж, “эртний баруун Хан улсын бичиг мэт хувилгаан сахиулсан чөтгөр шулмын хэрэг ба жигтэй илбэс увидасын явдал...”-ыг дагаж “Хөх судар”-ыг туурвисан санаагаа илэрхийлсэн байжээ. Намжилцэвэг “Хөх сударт”-т хоёр зүйлийн үйл явдал бичигджээ гэж үзсэн байна. Нэг зүйл нь солио гажуу увидас, илбэс, бясалгал хийгээд этгээд онцгой ер бэлгэс жич чөтгөр шулмын зохиомол хэрэг учир, нөгөө нэг зүйл нь “Чингисийн баатруудтайгаа харьцсан харьцаа, баатруудын хоорондоо ба цэрэг иргэнтэй харилцсан харилцаа ...” зэрэг Монгол туургатаны түүхэн үнэн хэрэг явдал болно хэмээжээ. Намжилцэвэгийн үгээр хэлбэл “Хөх судар”-аас солио гажуу увидас, илбэс, бясалгал хийгээд этгээд онцгой ер бэлгэсийн жич чөтгөр шулмын зохиомол хэрэг учрыг аваад хаячихвал XIII зууны үеийн Монголын нийгмийн түүхийн үнэн хэрэг нь үлдэж “Уншигчдад худал гэж санагдахгүй харин итгэгдэж үнэмшигдэх” болно гэжээ.

4. Уран зохиолын хүмүүжлийн ач холбогдол:

Намжилцэвэгээс Инжинашийн “Тэнэт бас өдөр удааны хүчинд бүтэж гараад орчлонгийн хооронд хоцрон үлдэхэд хүрвэл харин ч хожмын мэргэдэд нэлээд сэргэх сэнхрэх гавьяа тус болох ч магадгүй...” гэсэн үгийг эшлэж Монгол туургатаны соён гэгээрэхэд үйлдэл үзүүлэх тухай ярьжээ.

5. Шүлгийн онцлог ба орчуулгын зарчим:

6. Монголынхоо соёл ба онцлогийг хөгжүүлэх тухайд:

Намжилцэвэгээс Инжинашийг үндэстний соёлоо эрхэмлэн хүндэтгэдэг үзэл санааг хэлээд хуудас хэмжээ үзүүлж ярьсан байдаг. Жишээлбэл: “... Манай газрын хянамгагүй ард өөрөө өөрийн Монгол үг ба Монгол үсгээ басамжлан, Монгол үсгээр иргэний санааг бүртгэн гаргаж хэрхэн чадмуй гэж амны аяар чалчмуй. Тэр маш их даяаршсан хэрэг болой.... Хэрэв хэрэглэвээс үсэг юун мөхөж болох аж. Тийнхүү өөрөө

эс хичээгээд далд нууц бүгдэм үсгүүдийг нэвтэрсэн үгүй бөгөөд Монгол үгс ямар гүн хол, хүнд тусалт бий хэмээх нь далайн хөвөөнд биеэ угаагаад далайг гүйхэн үзсэнээс юун өөр буй” гэсэн Инжинашийн үг эшлэж байгаад үндэсний хэлний соёлоо дээдлэн эрхэмлэх санааг илэрхийлжээ.

7. Зохиолчийн хөдөлмөрийн тухайд:

Намжилцэвэгээс Инжинашийг “унтах нойр, идэх хоолгүйгээр өдөр, шөнө залгалдан мунхаг оюуны хэрээр чин үнэнээр эрсээр арай эс алмайтан солиоров. Энэ үнэхээр мунхаг оюуны хэрээр сэтгэлийн цусыг бөөлжиж нүдний хэрээр олон олон судрыг шинжиж гүйхэн мэдлийн хэрээр хүн ба газрын нэрийг эрж, үзгэн чадлын хэрээр цөлбөн бичиж....” гэсэн үг бол зохиолчийн шаргуу хөдөлмөрч чанарын тухай өгүүлсэн гэж үзжээ.

Үнэндээ XIX зууны нэрт утга зохиолч Инжинаш бидэнд “уран зохиол гэж юу вэ? ямар онцлогтой байх вэ? Яаж бичвэл зохих, уран зохиол нь хүмүүст юу өгдөг юм гэдгийг дуртгаад Монгол, Хятад, Төвөд, Манж шүлэг ямар онцлогтойг судлан тодорхойлж өгсөн...” бөгөөд бас уран зохиолын түгээмэл жам хуулийг оновчтой сайхан өгүүлж чадсанаар үл барам бас уран зохиолын өвөрмөц чанарын зан хуулийг ч тодорхой өгүүлсэн юм. Үүнийг эрдэмтэн Намжилцэвэгийн судалгаа нотолсон төдийгүй Инжинашийн “Хөх судар”-ын товчит тольтийн тус биеийнх нь баялаг агуулга бидэнд хангаж өгсөн билээ.

2. “Хөх судар” -ын үзэл санааны судлал

Нэгэн шилдэг содон уран бүтээл нь утга төгөлдөр учраас, олон зүйлийн аргаар судалж болдог. Зарим эрдэмтэн соёл зүйн үзэлт болон арга зүйгээр судалж байхад зарим эрдэмтэн гоо сайхны онол үзэлт ба арга зүйгээр шинжилж байна. Гэтэл эрдэмтэн Намжилцэвэг Инжинашийн түүхэн роман “Хөх судар”-ыг улс төрийн шүлэг зүйгээр ашиглаж “Хөх судар”-ын соён гэгээрүүлэх үзэл санааг түлхүү анхаарч судалсан байна. Эрдэмтэн Намжилцэвэгийн дараа 1964 онд Германы монголч эрдэмтэн Валтер Хайссиг

“Монголын түүх ба соёл” гэдэг номондоо Инжинашийн “Шүүмжлэлийн асуудал нь Францын соён гэгээрүүлэх үзлийг түгээхтэй нэгэн адил болох байна...” хэмээн үзэв. Энэхүү хоёр эрдэмтэн цөм Инжинашийн “Хөх судар”-ын үзэл санааны үнэ цэнийн асуудлыг дээд зэргээр ойшоон үнэлжээ.

Намжилцэвэгээс “түүхэн уран зохиолын үндэслэл нь баримт дээр тулгуурладаг учир түүхийн зохиолын онцлог болж түүхэн бодит хүн, үйл явдлын баримтыг зохиолч өөрийн хэлэх гэсэн санаандаа зохицуулж дүрслэх” юм хэмээн дүгнэн бичсэн нь бий. Энэ бол түүхэн уран зохиолын хамгийн гол онцлог тал гэж үзжээ. Иймээс “Хөх судар” бол түүхэн роман болно. Намжилцэвэгийн удирдагч багш эрдэмтэн Ц.Дамдинсүрэн 1959 онд найруулан хэвлүүлсэн “Монгол уран зохиолын дээж зуун билиг оршив”-доо “Хөх судар” түүхэн романы үйл явдлын талаар “Нууц товчоотой төсөөтэй баймуй. Гэвч үзэл санаа нь их өөр баймуй. Инжинаш түүхийг бичсэн биш, түүхэн роман бичсэн учир ерөнхий чиглэлийг дагуулан нэмж чимэглэсэн зүйл цөөнгүй” гэжээ. 1964 онд “Түүхэн үлгэрийн зохиол” гэж үзэв. 1973 онд Иохан Хангин Гомбожав докторын зэрэг хамгаалсан өгүүллээ “Хөх судар” нь Инжинашийн зохиосон Монголын хамгийн анхны түүхийн романы судлал гэж гарчиглаад “Хөх судар”-ын уран зохиолын хэв шинжийг голчлон судлан өгүүлсэн байжээ.

Монгол утгын сургаалийн хурал анх 1940 онд Бөх хишиг чуулганаар хэвлэн гаргасны хойно Монголын олон бичигтэн цөмөөр “Хөх судар”-ыг Монголын түүхээр үзэж уншиж байв. Харин XX зууны 50-иад оны сүүлчээс хойш “Хөх судар”-ыг түүхэн роман хэмээн үзэх болов, гэтэл одоо нэг хэсэг эрдэмтэд Монголын түүхийн тулгар бичигт оруулж судалж байна. Тэгвэл Инжинашийн зохиосон “Их Юань улсын мандсан төрийн хөх судар” яахлаараа иймэрхүү хоёр зүйлийн үзэлт бий болов? гэдэг асуудал зүй ёсоор урган гарч ирнэ.

ДҮГНЭЛТ

Монголын утгын сургаалийн хурлын чуулганаар хэвлэн гаргасан “Хөх судар”-ыг тухайн үеийн бичиг соёлтой хүмүүс Монгол туургатаны түүх хэмээн үзэж байсан баримт гэвэл:

1. XX зууны дөчөөд онд нэг зүйлийн үзэл урсгал бий болсон. Инжинашийн “Хөх судар” болон “Хөх судар”-ын товчит тольтийн соён гэгээрүүлэх үзэл санааг шууд хүлээж “Хөх судар”-ыг Монгол туургатаны “Төв судар” буюу жинхэнэ түүх болгож, Өвөр Монголын хэмжээнд Монголын мандсан үеэ сэргээн босгох оршил бий болов. Үүний гэрч баримт бол “Хөх туг хоршоо” байгуулж “Хөх туг сонин”, “Их хөх” туг сэтгүүл зэргийг эрхэлж Инжинашийн “Хөх судар”-ыг заалган нийтэлж олон Монголчуудыг соён гэгээрүүлэх үзэл санааг дэлгэрүүлэхийг зорьжээ. Энэ бол утга зохиолын том үйл байсан хэмээн үзэж болно. Онцгойлон Өвөр Монголын зүүн орны олон бичгийн хүмүүс “Хөх тугийн магтаал” бичсэн төдийгүй “Хөх Монгол”-оор сэдэвлэсэн шүлэг зохиол бичиж нийтлүүлсэн байдаг юм.
2. Өвөр Монголын зүүн орны өвгөчүүд хуучлахдаа өнгөрсөнд “Хөх судар”-ыг Монгол туургатаны түүхээр үзэж түүх болгож уншиж байжээ. Тэр ерөөс тухайн үед “Монголын нууц товчоо”, “Алтан товч” “Эрдэнэсийн товч” зэрэг Монгол туургатаны түүхийн тулгар бичгийг олж уншаагүй байжээ.
3. 1936 онд утга зохиолч, түүхчийн зохиосон “Их Монголын Юань улсын судар” “Цахар Монголын бичиг зураг зохион орчуулах хүрээ”-г сэдэн байгуулж түүнд ажиллаж байсан мянган хошууны Зодовжав амбан болон цахарын хөвөөт шар хошууны амбан Төмөрболд авгай хоёр энэ бичгийг хянан тогтоож үзсэн “дагалдуулсан илтгэл”-д дээ бүр Саган тайжийн зохиол “Эрдэнийн товч” болон Инжинашийн “Хөх судар”-тай тулган харгуулж үзжээ. Үүнээс үзвэл Өвөр Монголын баруун орны бичгийн хүмүүс ч Инжинашийн “Хөх судар”-ыг Монголын түүхийн тулгар бичиг мөн хэмээн үзэж байв.



XXI зуунд нэг хэсэг эрдэмтэд Монголын түүхийн тулгар бичигт багтаан судлах болов. Жишээлбэл: Монгол улсын эрдэмтэн Чоймаа багш Инжинашийн зохиосон “Хөх судар”-ыг “Монголын нууц товчоо”, “Алтан товч” -тай адилаар Монголын тулгар бичигт оруулж хэвлүүлсэн байна. Үүнээс үзвэл “Хөх судар”-ын түүхэн сурвалж бичгийн үүднээс “Хөх судар”-т-ыг шинжлэн үзсэн байна.

Эцэст нь дүгнэн хэлбэл түүхийн сурвалж бичиг болон түүхэн уран зохиол хоёр бол шинж чанарын хувьд ялгаатай, бидний судалгаанд түүх болон уран зохиолын заагийг тодорхой ялгавал зохино. Тиймээс Инжинашийн “Хөх судар” бол түүхэн роман болно. Уран зохиолын судалгааны хүрээнд мөн багтах буй за.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Дамдинсүрэн, Ц. (1990). *Монголын нууц товчоо*. Улаанбаатар. х.255
- Дамдинсүрэн, Ц. (эмх.). (1959). *Монголын уран зохиолын дээж. Зуун билэг оривой*. Улаанбаатар.
- Инжинаши, В. (1991). *Хөх судар*. Монгол бичгээр. (боть 1). Улаанбаатар. х.682
- Инжинаши, В. (1991). *Хөх судар*. Монгол бичгээр. (боть 2). Улаанбаатар. х.1361
- Инжинаши, В. (1991). *Хөх судар*. Монгол бичгээр. (боть 3). Улаанбаатар. х.2018
- Цэрэнсодном, Д. (1997). *Монголын бурханы шашины уран зохиол*. Улаанбаатар
- Хэл шинжлэлийн хүрээлэн*. (2006) *Эрдэнийн товч-Саган Сэцэн*. Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал 8. Улаанбаатар. х.366